



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/206

Хэрлэн сум

Улсын нөөцөөс хуваарилсан малын
тэжээлийг сумдад олгох хуваарь, тээврийн
зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар улсын нөөцөөс Хэнтий аймагт 60 тонн олгохоор шийдвэрлэсэн малын тэжээлийг татаж авах тээврийн зардалд зориулж 3,800,000 (гурван сая найман зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.


2. Малын тэжээлийн хуваарийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй,

4. Баталсан хуваарийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор сумдад хуваарилж дуусгахыг Онцгой байдлын газрын дарга (Ж.Эрдэнэбат)-д, малчдад олгох малын тэжээлийг зориулалтын бусаар зарцуулах, худалдан борлуулах зөрчлөөс урьдчилан сэргийлж хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



А/2004
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 16-ний өдрийн
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Хуваарь

№	Сумын нэрс	Тоо хэмжээ (тн)
1	Батноров	3
2	Батширээт	2
3	Баян-Адрага	3
4	Баянмөнх	2
5	Баян-Овоо	3
6	Баянхутаг	2
7	Биндэр	3
8	Бор-Өндөр	2
9	Галшар	3
10	Дадал	3
11	Дархан	2
12	Дэлгэрхаан	4
13	Жаргалтхаан	3
14	Мөрөн	2
15	Норовлин	3
16	Өмнөдэлгэр	4
17	Хэрлэн	4
18	Цэнхэрмандал	2
19	Аймгийн нөөцөд	10
	Нийт	60

Аймгийн Засаг даргын 2025 оны
 дугаар сарын 16-ний өдрийн
 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Зардлын тооцоо

д/д	Нэрс	Км (ирж очих)	Шатахуун (литр)	Нэг бүрийн үнэ	Тэжээл	Нийт үнэ
1	Хэнтий-Түмэнцогт- Хэнтий (2 удаа тээвэр)	600	300	3250	-	975,000
	Тээврийн зардал	-	-	47084	60 тн	2,825,000
	НИЙТ ЗАРДАЛ	-	-	-	-	3,800,000